



## ЭРЧИМ ХҮЧНИЙ ЗОХИЦУУЛАХ ХОРООНЫ ТОГТООЛ

2014 оны 12 сарын 10 өдөр

Дугаар 239

Улаанбаатар хот

### Аргачлал батлах тухай

Эрчим хүчний тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.1.4 дэх заалтыг үндэслэн Эрчим хүчний зохицуулах хорооноос **ТОГТООХ нь:**

1. "Цахилгаан, дулааны эрчим хүчний үнэ тарифыг тогтоох аргачлал"-ыг хавсралтын ёсоор баталсугай.

2. Батлагдсан аргачлалын дагуу үнэ тарифыг тооцож боловсруулахыг тусгай зөвшөөрөл эзэмшигч компаниудын захирал, дарга нарт, тусгай зөвшөөрөл эзэмшигчийн үнэ, тарифын тооцоо, саналыг хянаж, Эрчим хүчний зохицуулах хорооны хурлаар хэлэлцүүлж батлуулахыг Үнэ тарифын бодлого, зохицуулалтын хэлтэс /Б.Болор-Эрдэнэ/-т тус тус даалгасугай.

3. Энэ тогтоол батлагдсантай холбогдуулан Эрчим хүчний зохицуулах хорооны 2013 оны 88 дугаар тогтоолыг хүчингүй болсонд тооцсугай.

ДАРГА

ЗОХИЦУУЛАГЧ

ЗОХИЦУУЛАГЧ

ЗОХИЦУУЛАГЧ

С.ОТГОНБАЯР

Д.БАССАЙХАН

Р.МЯГМАР

Т.ГАНТӨМӨР





## ЦАХИЛГААН, ДУЛААНЫ ЭРЧИМ ХҮЧНИЙ ҮНЭ, ТАРИФЫГ ТОГТООХ АРГАЧЛАЛ

### Нэг. Ерөнхий зүйл

1.1. Энэхүү аргачлалын зорилго нь цахилгаан, дулаан үйлдвэрлэх үнэ, диспетчерийн зохицуулалт хийх, дамжуулах, түгээх, хангах тусгай зөвшөөрөл эзэмшигч /цаашид "ТЗЭ" гэх/-ийн үйлчилгээний төлбөр, тариф, хэрэглэгчдэд худалдах үнийг тогтооход оршино.

1.2. Тусгай зөвшөөрөл эзэмшигч нь тусгай зөвшөөрөлд заасан үйл ажиллагааны сүүлийн 3 жилийн бодит зардлын гүйцэтгэлд тулгуурлан энэхүү аргачлалын дагуу тарифыг тооцож, саналыг ЭХЗХ-д оруулна.

1.3. Үнэ тарифын тооцоонд техник эдийн засгийн үзүүлэлт, эрчим хүчний баланс, төлөвлөгөөнд тусгагдаагүй зардлын үндэслэлийг холбогдох тайлбар, тооцооны хамтаар хавсаргана.

### Хоёр. Нэр томъёо

Энэхүү аргачлалд хэрэглэсэн дараахь нэр томъёог дор дурдсан утгаар ойлгоно.

2.1. **"Борлуулалтын орлогын шаардагдах хэмжээ (БО<sub>ш</sub>)"** - Тусгай зөвшөөрөлд заасан үйл ажиллагааны нийт зардал, хөрөнгө оруулалтын өгөөжийг тусгасан борлуулалтын орлого;

2.2. **"Бүрэн өөрийн өртөг (БӨӨ)"** – Бүх төрлийн зээлийн хүү, ажиллагсдын нийгмийн зардлыг оролцуулаагүй өөрийн үндсэн үйл ажиллагааны зардлын нийлбэр;

2.3. **"Эрх бүхий байгууллагаар баталгаажсан татаас"** – Засгийн газар, орон нутгийн засаг захиргаа болон бусад байгууллагаас олгох санхүүжилт;

2.4. **"Хөндлөн татаас"**-Цахилгааны тарифт шингээх дулааны үйлдвэрлэлийн санхүүгийн алдагдлын хэмжээ;

2.5. **"Үйлчилгээний биет хэмжээ"** - Үйлдвэрлэх, дамжуулах, түгээх, хангах, диспетчерийн зохицуулалт хийх эрчим хүчний тоо хэмжээ;

2.6. **"Хөрөнгө оруулалтын өгөөж"** - Хөрөнгө оруулалтаас олох урт хугацаат зээлийн хүүгийн зардал, ажиллагсдын нийгмийн зардлыг тусгасан ашгийн хэмжээ;

2.7. **"Хөрөнгө оруулалтын өгөөжийн хувь"** - Урт хугацаат зээлийн хүү, өөрийн хөрөнгийн өгөөжийн хувийн жигнэсэн дундаж;

## Гурав. Эрчим хүчний үнэ тарифыг тогтооход баримтлах зарчим

3.1. ТЗЭ-ийн бүрэн өөрийн өртгийг сүүлийн 3 жилийн бодит өртөг зардлын гүйцэтгэлд үндэслэн тогтоох ба хөрөнгө оруулалт, шинэчлэлийн үр дүнд ирээдүйд бий болох хөрөнгөнд тооцогдох элэгдэл, хорогдлын зардлыг тусгахгүй. Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээ хийсний үр дүнд нэмэгдсэн үндсэн хөрөнгийн хэсэгт тооцсон элэгдлийн зардлыг нарийвчлан хянаж, бүрэн өөрийн өртөгт тусгах эсэхийг шийдвэрлэнэ.

3.2. Тариф тогтоох хугацааны үйлчилгээний биет хэмжээ, худалдан авах эрчим хүчний хэмжээг тодорхойлоход ЭХЗХ-оос тогтоосон дотоод хэрэгцээний цахилгаан, дулааны зарцуулалт, шугамын алдагдал, ДҮТ ХХК-иас тогтоосон үйлдвэрлэлт, түгээлтийн төлөвлөгөөнд үндэслэнэ.

3.3. Санхүүжилтийн эх үүсвэр нь Засгийн газрын эрх бүхий байгууллагаар баталгаажсан нөхцөлд татаасыг тарифын тооцоонд оруулж тооцно.

3.4. Үнэ тариф тооцох зардалд тусгай зөвшөөрөлд заасан үйл ажиллагаанд хамааралгүй бүх төрлийн шагнал урамшуулал тэтгэмж, бусдад өгсөн хандив, бэлэг дурсгал, хүлээн авалт, туслах аж ахуй, амралт, сувилал, гуанз, цайны газрын зардал ба бусад үйлдвэрлэлийн бус үйлчилгээний зардлыг оруулахгүй.

3.5. Дамжуулах, түгээх, хангах ТЗЭ-ийн худалдах, худалдан авах эрчим хүчний хэмжээний өөрчлөлт, хэрэглээний бүтэц, хэрэглэгчийн үнийн өөрчлөлтөөс хамааран хэрэглэгчийн дундаж үнэд өөрчлөлт орж, орлого нэмэгдэх тохиолдолд үйлчилгээний хувьсах ба тогтмол төлбөрт нийцүүлэн худалдан авах үнэд өөрчлөлт оруулна. Харин орлого буурсан тохиолдолд ТЗЭ санал ирүүлбэл борлуулалтын орлогын шаардагдах хэмжээнд нийцүүлэн худалдан авах үнэд зохих өөрчлөлт оруулна.

3.6. ТЗЭ-ийн суурилагдсан хүчин чадал, үйлчилгээний хамрах хүрээ өөрчлөгдсөн нь тухайн ТЗЭ-ийн санхүүгийн чадавхид нөлөөлөхүйц байх тохиолдолд худалдах, худалдан авах үнэд зохих өөрчлөлт оруулна.

### Дөрөв. ТЗЭ болон хэрэглэгчийн цахилгаан, дулааны эрчим хүчний үнэ тарифын тооцоо

4.1. ТЗЭ-ийн эрчим хүчний тарифыг цахилгаан, дулаан үйлдвэрлэх, диспетчерийн зохицуулалт хийх, дамжуулах, түгээх, хангах ТЗЭ тус бүрээр тогтооно.

4.1.1. Үйлдвэрлэх ТЗЭ-ийн тариф  $T_v$ -ыг борлуулалтын орлогын шаардагдах хэмжээ  $BO_{ш.ү}$ -ээс эрх бүхий байгууллагаар баталгаажсан татаас  $ТС_{зг}$ -ыг хасаж үйлчилгээний биет хэмжээ  $Y_{б.х}$ -нд харьцуулж тодорхойлно. Тарифыг төгрөг мөнгөөр буюу зууны нарийвчлалтай гаргана.

$$T_v = \frac{BO_{ш.ү} - TC_{зг}}{Y_{б.х}} \quad \{\text{төг/кВт.ц, төг/Гкал}\}$$

4.1.2. Диспетчерийн зохицуулалт хийх тусгай зөвшөөрөл эзэмшигчийн тариф  $T_d$ -ыг дараах байдлаар тогтооно.

$$T_d = \frac{BO_{ш.д} - TC_{зг}}{12} \quad \{\text{мян.төг/сар}\}$$

4.1.3. Дамжуулах, түгээх, хангах тусгай зөвшөөрөл эзэмшигчийн үйлчилгээний төлбөр хувьсах  $T_{дтх,хув}$  ба тогтмол  $T_{дтх,тог}$  хэсгээс бүрдэх ба дараах байдлаар тогтооно.

$$T_{дтх,хув} = \frac{(BO_{ш.дтх} - TC_{зг}) \times 0.1}{Y_{б.х}} \quad \{\text{төг/кВт.ц; төг/Гкал}\}$$

$$T_{дтх,тог} = \frac{(BO_{ш.дтх} - TC_{зг}) \times 0.9}{12} \quad \{\text{төг/сар}\}$$

4.2. Хэрэглэгчийн дундаж үнэ  $T_{хэр}$ -ийг эрчим хүчний нэгдсэн системд хамаарах бүх ТЗЭ-ийн борлуулалтын орлогын шаардагдах хэмжээ, импортоор худалдан авах эрчим хүчний зардал **ИМХАЦЗ**-ын нийлбэрийг тухайн системийн үйлчилгээний биет хэмжээнд харьцуулах байдлаар тогтооно.

$$T_{хэр} = \frac{(BO_{ш.ү} + BO_{ш.д} + BO_{ш.дтх} - TC_{зг}) + \text{ИМХАЦЗ}}{Y_{б.х}} \quad \{\text{төг/кВт.ц; төг/Гкал}\}$$

4.3. Түгээх, хангах ТЗЭ-ийн худалдан авах эрчим хүчний тарифыг хэрэглэгчийн үнээр тооцсон борлуулалтын орлого **БО** ба борлуулалтын орлогын шаардагдах хэмжээ  $BO_{ш.тх}$ -ний ялгаврыг худалдан авсан эрчим хүчний биет хэмжээ  $ХАЦ_{б.х}$ -нд харьцуулах байдлаар тогтооно.

$$T_{тх,хац} = \frac{BO - (T_{дтх,хув} \times Y_{б.х} + T_{дтх,тог} \times 12)}{ХАЦ_{б.х}} \quad \{\text{төг/кВт.ц}\}$$

4.4. Үнэ тарифыг тооцоолохын тулд борлуулалтын орлогын шаардагдах хэмжээг тодорхойлно. Борлуулалтын орлогын шаардагдах хэмжээ  $BO_{ш}$  нь үйл ажиллагааны нийт зардал **НЗ**-ын дүн болон хөрөнгө оруулалтын өгөөж **ХОӨ**-ийн нийлбэрээр тодорхойлогдоно.

$$BO_{ш} = НЗ + ХОӨ$$

4.5. Нийт зардлын дүн **НЗ** нь тусгай зөвшөөрөлд заасан үйл ажиллагааны бүрэн өөрийн өртөг **БӨӨ**, богино хугацаат зээлийн хүүгийн зардал  $Z_{хүү}$  болон дулааны хандлан татаасын зардал  $ТС_d$ -ын нийлбэрээр тодорхойлогдоно. Татаасын зардал нь зөвхөн цахилгаан, дулаан хослон үйлдвэрлэх тусгай зөвшөөрөл эзэмшигчид хамаарна.

$$НЗ = БӨӨ + Z_{хүү} + TC_3$$

4.6. Хөрөнгө оруулалтын өгөөж **ХОӨ**-ийг тодорхойлохдоо өгөөж тооцох хөрөнгө оруулалт  $ХО_{өт}$ -ын дүнг хөрөнгө оруулалтын өгөөжийн хувь  $ХО_{өх}$ -иар үржүүлнэ.

$$ХОӨ = ХО_{өт} * ХО_{өх}$$

4.7. Хөрөнгө оруулалтын өгөөжийн хувь  $IXO_{ex}$ -ийг хөрөнгө оруулалтын эх үүсвэрүүдэд урт хугацаат зээл  $IYX3$ -ийн хүүгийн хувь  $IYX3_{xx}$  ба эзэмшигчийн өмч  $IЭӨ$ -ийн өгөөжийн хувь  $IЭӨ_{ex}$ -ийн жигнэсэн дундажаар тодорхойлогдоно.

$$XO_{ex} = \frac{(YX3 \times YX3_{xx}) + (ЭӨ \times ЭӨ_{ex})}{YX3 + ЭӨ}$$

4.8. Өгөөж тооцох хөрөнгө оруулалтын дүн  $IXO_{et}$ -ыг өгөөж тооцох үндсэн хөрөнгийн дүн  $IYX_{et}$  болон өгөөж тооцох эргэлтийн хөрөнгийн дүн  $IЭX_{et}$ -гийн нийлбэрээр тооцно.

$$XO_{et} = YX_{et} + ЭX_{et}$$

4.9. Өгөөж тооцох үндсэн хөрөнгийн дүн  $IYX_{et}$ -г тусгай зөвшөөрөлд заасан үйл ажиллагаатай холбогдох үндсэн хөрөнгийн анхны өртөг  $IYX_{ae}$ -өөс хуримтлагдсан элэгдэл  $IЭ_{хур}$ -ийг хасаж тодорхойлно.

$$YX_{et} = YX_{ae} - Э_x$$

4.10. Өгөөж тооцох эргэлтийн хөрөнгийн дүн  $IЭX_{et}$ -г тусгай зөвшөөрөлд заасан үйл ажиллагаатай холбогдох эргэлтийн хөрөнгө  $IЭX$ -өөс богино хугацааны өр төлбөр  $IӨT_{bx}$ -ийг хасаж тодорхойлно.

$$ЭX_{et} = ЭX - өT_{bx}$$

#### Тав. Бусад

5.1 Цахилгаан, дулаан хослон үйлдвэрлэх ТЗЭ-ийн түлшний зардлыг жишмэл түлшний зарцуулалтын хувь хэмжээгээр цахилгаан, дулаанд хуваарилна.

5.2. Цахилгаан, дулаан хослон үйлдвэрлэх ТЗЭ-ийн тогтмол зардлыг цахилгаанд 70, дулаанд 30 хувиар тус тус хуваана.

5.3. Цахилгаан, дулаан хослон үйлдвэрлэх ТЗЭ-ийн дулааны санхүүгийн алдагдлыг хүснэгт № 5-ийн дагуу тодорхойлж цахилгааны үнэнд шингээж тооцно.

5.4. Дамжуулах болон түгээх, хангах тусгай зөвшөөрөл эзэмшигчийн худалдан авах эрчим хүчний үнэ нь дамжуулалт, түгээлтийн техникийн алдагдал болон үйлчилгээний төлбөрийг багтаасан байна.

5.5. Цахилгаан түгээх, хангах ТЗЭ түгээлтийн шугамын алдагдлын хэмжээг бууруулсантай холбоотой нэмэгдэх үйл ажиллагааны орлогыг тухайн ТЗЭ-ийн борлуулалтын орлогын шаардагдах хэмжээнд урамшуулал хэлбэрээр нэмэгдүүлж тооцно.

5.6. Тусгай зөвшөөрөл эзэмшигч нь тарифын тооцоог хянахад шаардлагатай дараахь материалыг хавсаргана. Үүнд :

а/ Цахилгаан, дулааны эрчим хүчний тарифын тооцоо /Хүснэгт №1/

б/ ТЗЭ-ийн бүрэн өөрийн өртөг, нийт зардлын санал, сүүлийн 3 жилийн гүйцэтгэл /Хүснэгт №2/

в/ Үйлдвэрлэх ТЗЭ-ийн дулааны эрчим хүчний санхүүгийн алдагдлын тооцоо /Хүснэгт №3/

г/ Цахилгаан, дулааны эрчим хүч үйлдвэрлэх, дамжуулах, түгээх, хангах ТЗЭ-ийн техник, эдийн засгийн үзүүлэлтийн өмнөх онуудын гүйцэтгэл, санал /Хүснэгт №4, 5, 6, 7/

д/ Тарифын тооцоонд ашигласан түлш, түүхий эд, сэлбэг материал, үйлчилгээний үнэ, тарифын жагсаалт

е/ Тарифын тооцоонд оруулсан татаасын орлого олгох тухай Засгийн газрын эрх бүхий байгууллагын шийдвэр, урт богино хугацааны зээлтэй холбоотой баримт материал

---- оОо ----

..... ХК-ийн эрчим хүчний тарифын тооцоо

Хүснэгт №1

№	Үзүүлэлт	д/д	Хэмжих нэгж	Үйлдвэрлэх		ЦЭХ дамж	Цахилгаан		Дулаан		Нийт дүн
				Цахилгаан	Дулаан		Түгээх	Хангах	Түгээх	Хангах	
I	Тариф	1	төг/кВт.ц төг/Гкал м.төг/сар								
II	Үйлчилгээний биет хэмжээ	2	м.кВтц Гкал								
III	Борлуулалтын орлогын шаардагдах хэмжээ /4+8/	3	м.төг								
IV	Нийт зардлын дүн /5+6+7/	4	м.төг								
	Бүрэн өөрийн өртөг	5	м.төг								
	Зээлийн хүүгийн зардал	6	м.төг								
	Татаасын зардал	7	м.төг								
V	Хөрөнгө оруулалтын өгөөж /10*9/	8	м.төг								
VI	Хөрөнгө оруулалтын өгөөжийн хувь	9	%								
VII	Өгөөж тооцох хөрөнгө оруулалтын дүн /11+14/	10	м.төг								
VIII	Өгөөж тооцох үндсэн хөрөнгийн дүн /12-13/	11	м.төг								
	Үндсэн хөрөнгө	12	м.төг								
	Хуримтлагдсан элэгдэл	13	м.төг								
IX	Өгөөж тооцох эргэлтийн хөрөнгийн дүн /15-16/	14	м.төг								
	Нийт эргэлтийн хөрөнгө	15	м.төг								
	Богионо хугацааны өр төлбөр	16	м.төг								
X	Татаасын орлого	17	м.төг								

..... ХК-ийн тусгай зөвшөөрлийн үйл ажиллагааны нийт зардал  
/өмнөх 3 жилийн гүйцэтгэл, санал/

мян.төг

Хүснэгт №2

№	Зардлын төрлүүд	Үйлдвэрлэх		ЦЭХ дамж- х	Цахилгаан		Дулаан		Нийт дүн
		Цахилгаан	Дулаан		Түгээх	Хангах	Түгээх	Хангах	
1	Түлшний зардал								
2	Усны зардал								
3	Цахилгааны зардал								
4	Түүхий эд материал								
5	Шатахууны зардал								
6	Тээврийн зардал								
7	Сэлбэг хэрэгсэл								
8	Урсгал засвар								
9	Материал, хангамж ийн материал								
10	Үндсэн ба нэмэгдэл цалин, урамшуулал								
11	Байгууллагаас төлөх ЭМ, НДШ								
12	Ашиглалтын зардал- Цахилгаан								
13	Ашиглалтын зардал- Дулаан								
14	Ашиглалтын зардал-Ус								
15	Албан томилолтын зардал								
16	Конторын хангамж ийн зардал								
17	Харилцаа холбооны зардал								
18	Харуул хамгаалалтын зардал								
19	Хөдөлмөр хамгааллын зардал								
20	Даатгалын зардал								
21	Байгаль орчин хамгаалах зардал								
22	Галын аюулаас хамгаалах зардал								
23	Гүйцэтгэх удирдлагын зардал								
24	Төлөөлөн удирдах зөвлөлийн зардал								
25	Борлуулалт, маркетингийн зардал								
26	Диспетчерийн зардал								
27	Зохицуулалтын үйлчилгээний хөлс								
28	Гадны үйлчилгээний хөлс								
29	Түрээсийн зардал								
30	Сургалтын зардал								
31	Найдваргүй авлагын зардал								
32	Үйл аж иллагааны								



	бусад зардал								
<b>Үйл ажиллагаан зардлын дүн</b>									
<b>ҮХЭ-ийн зардлын дүн</b>									
33	Үл хөдлөх хөрөнгийн татвар								
34	АТӨЯХ-ийн албан татвар								
35	Газрын төлбөр								
36	Бусад татвар хураамж								
<b>Орлогын албан татвараас бусад татвар</b>									
<b>БҮРЭН ӨӨРИЙН ӨРТӨГ</b>									
37	Богино хугацаат зээлийн хүү								
38	Татаасын зардал								
<b>НИЙТ ЗАРДАЛ</b>									

**Тайлбар:** Урт хугацаат зээлийн хүү, ажиллагсдын нийгмийн зардлыг энэхүү хүснэгтэд тусгахгүй ба хөрөнгө оруулалтын өгөөжийн дүнд багтсан байна.

### Дулааны эрчим хүчний санхүүгийн алдагдлын тооцоо

Хүснэгт №3

№	Үзүүлэлтүүд	Хэмжих нэгж	Дүн
	Нийт дулаан түгээлт	мян.Гкал	
1	Үүнээс: Усаар	мян.Гкал	
	Уураар	мян.Гкал	
	Дулааны эрчим хүч худалдах тариф	төг/гкал	
2	Үүнээс: Усаар	төг/гкал	
	Уураар	төг/гкал	
	Дулааны нийт орлого	мян.төг	
3	Үүнээс: Усаар	мян.төг	
	Уураар	мян.төг	
	Дулааны нийт зардал	мян.төг	
4	Үүнээс: Усаар	мян.төг	
	Уураар	мян.төг	
	Санхүүгийн алдагдал	мян.төг	
5	Үүнээс: Усаар	мян.төг	
	Уураар	мян.төг	

..... ХК-ийн үйлдвэрлэх тусгай зөвшөөрөл /ДЦС/-ийн техник эдийн засгийн үзүүлэлтүүдийн өмнөх онуудын гүйцэтгэл, санал

Хүснэгт №4

№	Үзүүлэлтүүд	Хэмжих нэгж	Өмнөх оны гүйцэтгэл			Өмнөх тарифт туссан	ТЗЭ-ийн санал
			... он	... он	... он		
1	<b>Боловсруулсан цахилгаан</b>	<b>м.кВтц</b>					
2	Боловсруулсан дулаан	м.Гкал					
3	Дотоод хэрэгцээний цахилгаан	м.кВтц					
	Хувиар	%					
4	<b>Түгээсэн цахилгаан</b>	<b>м.кВтц</b>					
5	Түгээсэн дулаан	м.Гкал					
6	<b>Борлуулалтын орлого</b>		<b>м.төг</b>				
	Үүнээс:	цахилгааны	м.төг				
		дулааны	м.төг				
		татаас	м.төг				
7	<b>Нэгжийн үнэ</b>	<b>Цахилгаанд</b>	<b>төг/кВтц</b>				
		<b>Дулаанд</b>	<b>төг/Гкал</b>				
8	Нийт зардал		м.төг				
	Үүнээс:	цахилгаанд	м.төг				
		дулаанд	м.төг				
9	<b>Нэгжийн өртөг</b>	<b>Цахилгаанд</b>	<b>төг/кВтц</b>				
		<b>Дулаанд</b>	<b>төг/Гкал</b>				
10	Нийт ашиг алдагдал		м.төг				
	Үүнээс:	цахилгаанаас	м.төг				
		дулаанаас	м.төг				
11	<b>Жишмэл түлшний хувийн зарцуулалт</b>	<b>цахилгаанд</b>	<b>гр/кВтц</b>				
		дулаанд	кг/гкал				

..... ХК-ийн цахилгаан түгээх хангах тусгай зөвшөөрлийн техник эдийн засгийн үзүүлэлтүүдийн өмнөх онуудын гүйцэтгэл, санал

Хүснэгт №5

№	Үзүүлэлт		Хэмжих нэгж	Өмнөх оны гүйцэтгэл			Өмнөх тарифт туссан	ТЗЭ-ийн санал
				... он	... он	... он		
1	<b>Худалдаж авсан ЦЭХ</b>		мян.кВт.ц					
2	Түгээлтийн алдагдал	биет	мян.кВт.ц					
		хувь	%					
3	<b>Борлуулсан ЦЭХ</b>		мян.кВт.ц					
	Үүнээс: ААНБ		мян.кВт.ц					
	Орон сууц		мян.кВт.ц					
	Гэр хороолол		мян.кВт.ц					
4	<b>Нийт орлого</b>		<b>сая төг</b>					
	Борлуулалтын орлого		сая төг					
	Үүнд: ААНБ		сая төг					
	Орон сууц		сая төг					
	Гэр хороолол		сая төг					
	Татаасын		сая төг					
	Төлбөрт үйлчилгээний орлого		сая төг					
5	<b>Нийт зардал</b>		<b>сая төг</b>					
	БОШХ		сая төг					
	ХАЦЭХ-ний өртөг		сая төг					
6	Үйл аж иллагааны ашиг, алдагдал		сая төг					
7	Борлуулалтын дундаж тариф		төг/кВт.ц					
8	ХАЦЭХ-ний тариф		төг/кВт.ц					
9	Цахилгаан түгээх, хангах үйлчилгээний төлбөр		мян.төг/сар					
10	Цахилгаан түгээх, хангах үйлчилгээний тариф		төг/кВт.ц					
11	Хэрэглэгчдийн тоо		сая төг					
	Уул уурхай		сая төг					
	Бусад ҮААНБ		сая төг					
	Орон сууц		сая төг					
	Гэр хороолол		сая төг					

**Тайлбар:** ЦЭХ-ний тарифын ангиллаас хамааруулан хэрэглээ, тариф, борлуулалтын орлогоор нь сарын хуваарьтай гаргаж хавсаргах

..... ХК-ийн цахилгаан дамжуулах тусгай зөвшөөрлийн  
техник эдийн засгийн үзүүлэлтүүдийн өмнөх онуудын гүйцэтгэл, санал

Хүснэгт №6

№	Үзүүлэлт	Хэмжих нэгж	Өмнөх оны гүйцэтгэл			Өмнөх тарифт туссан	ТЗЭ-ийн санал
			... он	... он	... он		
1	Дамжуулалтанд авсан ЦЭХ	мян.кВт.ц					
2	Дамжуулалтын алдагдал	биет	мян.кВт.ц				
		хувь	%				
3	Дамжуулсан ЦЭХ	мян.кВт.ц					
	Түгээх сүлжээ	мян.кВт.ц					
	.....	мян.кВт.ц					
	Экспорт	мян.кВт.ц					
4	<b>Нийт орлого</b>	<b>сая төг</b>					
	Дамж уулалтын орлого	сая төг					
	Татаасын орлого	сая төг					
5	<b>Нийт зардал</b>	<b>сая төг</b>					
	Үйл аж иллагааны зардал	сая төг					
6	Үйл аж иллагааны ашиг, алдагдал	сая төг					
7	Цахилгаан дамжуулах үйлчилгээний төлбөр	мян.төг/сар					

..... ХК-ийн дулаан түгээх, хангах сүлжээний техник эдийн засгийн үзүүлэлтүүдийн өмнөх оны гүйцэтгэл, ... оны санал

Хүснэгт №7

№	Үзүүлэлтүүд	Хэмжих нэгж	Өмнөх оны гүйцэтгэл			Өмнөх тарифт туссан	ТЗЭ-ийн санал
			... он	... он	... он		
1	Худалдаж авсан ДЭХ	мян.Гкал					
	Үүнээс: ДЦС	мян.Гкал					
	.....	мян.Гкал					
2	Шугамын алдагдал	биет	мян.Гкал				
		хувь	%				
3	Борлуулсан ДЭХ	мян.Гкал					
	Үүнээс: ААНБ	мян.Гкал					
	Төсөвт байгууллага	мян.Гкал					
	Айл өрх	мян.Гкал					
4	Нийт орлого	мян.төг					
	Борлуулалтын орлого	мян.төг					
	Үүнээс: ААНБ	мян.төг					
	Орон сууц	мян.төг					
	Татаасын	мян.төг					
5	Нийт зардал	мян.төг					
	БОШХ	мян.төг					
	ХАДЭХ-ний өртөг	мян.төг					
	ОСНААК-иудын шимтгэл	мян.төг					
6	Үйл аж иллагааны ашиг, алдагдал	мян.төг					
7	Борлуулалтын дундаж тариф	төг/Гкал					
8	ХАДЭХ-ний тариф	төг/Гкал					
9	Дулаан түгээх, хангах үйлчилгээний тариф	мян.төг/сар					
10	Хэрэглэгчдийн тоо	тоо					
	ҮААНБ	тоо					
	Төсөвт байгууллага	тоо					
	Айл өрх	тоо					

**Тайлбар:** ДЭХ-ний тарифын ангиллаас хамааруулан хэрэглээ, тариф, борлуулалтын орлогоор нь сарын хуваарьтай гаргаж хавсаргах.